



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/168

Бат-Өлзий сум

Хоршоо хөгжүүлэх сангаас
зээл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр “Журам батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.2, 6.7, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар шалгарсан төслийн нэрс, мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.
2. Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээл болон барьцаа хөрөнгийн гэрээг холбогдох журмын дагуу байгуулж, зээлэнд шаардагдах нийт 138,000,000 (нэг зуун гучин найман сая) төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.
3. Хоршоо хөгжүүлэх сангийн зарцуулалт, зээлийн ашиглалт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлийн дарга (П.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 19-ны
өдрийн ...168...дугаар захирамжийн хавсралт

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН НЭРС,
МӨНГӨН ДҮН

Д/д	Зээлдэгчийн нэр	Регистрийн дугаар	Төслийн зориулалт	Санхүүжилт /сая. төгрөг/
1	Малчдын хамтын хүч хоршоо	3554422	Сүү, сүүн бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх	108.0
2	О.Батсүрэн	ХП61041809	Зөгийн бүл нэмэгдүүлэх	15.0
3	Г.Наранчимэг	ВМ86021423	Талх, нарийн боов хийх	15.0
Нийт				138.0